



**ЗАВХАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 57

Улиастай

“Жендэрийн тэгш байдлыг хангах” дэд
хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20 дугаар зүйлийн 20.1.14, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан аймгийн Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж, үр дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж, ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Батсайхан/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 72 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны хэлтсийн дарга /Д.Үнэнхүү/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.БАЛХЯРВАА

